



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 142

Булагтай

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө,  
шаардагдах зардлын хэмжээг батлах тухай

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 28 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хүдэр сумын 2019 оны байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг “хангалттай” гэж дүгнэсүгэй.


2. Сумын 2020 оны байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, шаардагдах зардлын хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Сумын байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллага, албан тушаалтнуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган, төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн зарцуулалтын байдалд тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийг зохих ёсоор тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Пүрэвдорж/-д даалгасугай.



ДАРГА Д. Пүрэвдорж Т.ЭРДЭНЭБАТ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн  
46 дугаар тогтоолын хавсралт.



2020 онд хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах ажлын  
төлөвлөгөө

№	Үндэслэсэн дунд хугацааны баримт бичиг	Хийгдэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцах эзэн	Шаардагдах төсөв, хөрөнгийн эх үүсвэр
<b>Нэг: Ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаар</b>						
1.1	Байгаль хамгаалах дэд хөтөлбөр /2020-2023/	Ойн зурвас байгуулах, ойжуулалтын ажлыг чанартай хийж гүйцэтгүүлэн хүлээж авах.	жилдээ	Ойн шувууны өвчинг арилгах, хамгаалалт сайжирч нөхөн сэргээлтийн чанарыг дээшлүүлнэ.	Ажлын хэсэг	ААНэгж, Ойн анги
1.2	АЗДУАХ-ийн 1.2.1	Ой мод, ургамлын хортон шавжийн голомт, нүүдлийн аюулаас урьдчилан сэргийлэх тандалт шинжилгээ, судалгааг хийж, Байгаль орчин аялал жуулчлалын яам, ойн судалгаа хөгжлийн төвд хүргүүлнэ.	2,3-р улиралд		Ойн анги, Байгаль хамгаалагч	БОАЖЯ, ОСХТөв БХНСАХ Зардлаас
1.3	СЗДУАХ-ийн 2.2.13 Байгаль хамгаалах дэд хөтөлбөр 3.3.9	2020 онд орон нутгийн хамгаалалтад авсан газрыг нөхөн сэргээх, ойжуулах, цэвэрлэх ажлыг зохион байгуулж, хүний болон байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалж доройтолд орох магадлалтай газрыг тогтоож зөвхөн ойг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.	Жилдээ	Хууль бусаар мод бэлтгэх, тээвэрлэлтийг таслан зогсоож, хууль эрх зүйн талаар мэдлэг олгоно. ААН, Нөхөрлөл, иргэнд байнгын болон түр ажлын байр бий болно.	Ойн анги байгаль хамгаалагч, БОХУБ, Ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуй нэгж, нөхөрлөл	Аймаг, сумын ИТХ-аас батлагдсан хуваарийн хэмжээгээр
1.4	СЗДУАХ-ийн 2.2.12 Байгаль хамгаалах дэд хөтөлбөр 3.3.8	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, 15 км түймрийн харлуулсан шороон зурвасыг сэргээх, Нүхэн гүүр, Цэнхэр гүүр чиглэлийн хяналтын цэгийг хуурайшилтын улиралд тогтмол ажиллуулах	2,3-р улиралд		ЗДТГазар Ойн анги, Байгаль хамгаалагч, ойн санг гэрээгээр эзэмшигч, нөхөрлөл, аж ахуй нэгж	Орон нутгаас Постын зардалд 5.500.000 Зурвас байгуулахад ААН-ийн зардлаар



1.5	Байгаль хамгаалах дэд хөтөлбөр 3.2.3, 3.2.4	Аж ахуй нэгж нөхөрлөлүүдэд байгаль орчны багц хууль зөрчлийн тухай хууль бусад шинэчлэгдсэн хууль дүрэм журмын талаар сургалт зохион байгуулж, иргэдэд экологийн боловсрол олгох зорилгоор хууль сурталчлах, байгалиа хамгаалах уриалга гарган гарын авлага мэдээллээр хангаж ажиллах	Жилдээ	БОХУБ, БХ, Ойн анги, Хэсгийн төлөөлөгч	Бичиг хэрэг, брошур эвлэлх 200.000
1.6	Байгаль хамгаалах дэд хөтөлбөр 3.3.6	Ойн сангийн талбайн хэсэглэлийн хил заагийг хаягжуулах ажлыг эхлүүлэх	Хавар, намар	Засаг дарга Ойн анги	ААН, нөхөрлөл, Ойн анги
1.7	СЗДУАХ-ийн 2.2.15	Хууль бусаар мод модон материал бэлтгэх, тээвэрлэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хөдөлгөөнт эргүүл шалгалтыг тогтмол хийх	Тухай бүрд нь	Ойн анги Байгаль хамгаалагч БОХУБ Цагдаагийн хэсэг	Орон нутгаас 2500.000
1.8	БОХТХуулийн 54.....	Байгаль хамгаалах тухай хуулийг зөрчсөн тухай үнэн зөв мэдээлэл өгсөн иргэн, илрүүлсэн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу урамшуулал олгох	Тухай бүрт	Засаг дарга БОХУБ БХамгаалагч Ойн анги	Хураагдсан эд зүйлийн борлуулсны орлогоос
1.9	Байгаль хамгаалах дэд хөтөлбөр 3.3.6	Аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран модны нөөцтэй алслагдсан газраас мод бэлтгэх ойн зам засах, зам гүүр янзлах	Жилдээ	Ойн анги, БХ, ААНэгж байгууллага	ААНэгжүүдийн хөрөнгөөр
1.10	Байгаль хамгаалах дэд хөтөлбөр	Байгалийн дагалт баялгийн ашиглалт хамгаалалтад хяналт тавих	Жилдээ	БОХУБ, Байгаль хамгаалагч	Орон нутгаас 300,000
<b>Хоёр: Уул уурхай ашиглалт, нөхөн сэргээлт, амьтны нөөцийн хомсдоллыг хамгаалах</b>					
2.1	Байгаль хамгаалах дэд хөтөлбөр 3.4.7	Булаг, рашааны усны ашигт чанарыг тогтоолгон хаягжуулж, тэмдэгжүүлэх сурталчлан хамгаалах	Жилдээ	Иргэдийн байгалиа хамгаалах идэвх нэмэгдэнэ.	Байгаль хамгаалагч, БЗДарга
Орон нутгаас 500,000					

2.2	Байгаль хамгаалах дэд хөтөлбөр 3.4.1	Ан агнуурын менежментийн төлөвлөгөөг үндэслэн ан амьтдыг хамгаалах өсгөн үржүүлэх, зүй зохистой ашиглах зорилгоор сумын хэмжээнд ан агнуурын 4 бүсэд хуваасныг үндэслэн орон нутгийн иргэдэд гэрээгээр хариуцуулах, төлөвлөгөөт болон хамтарсан эргүүл шалгалтыг зохион байгуулах	Жилдээ	Агнуурын бус нутаг эзэнтэй болно. Ховордож буй ан амьтдын тоо толгой өснө	Орон нутгаас 1,000,000
2.3	Байгаль хамгаалах дэд хөтөлбөр 3.5.8	Орон нутагт алт олборлох үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын судалгаа дүнг үндэслэн тухайн газарт техникийн болон биологийн, дүйцүүлэн нөхөн сэргээлтийг хийлгэнэ.	2,3-р улиралд	Нөхөн сэргээлт нэмэгдэж, эвдрэлд орсон газрын хэмжээ багасаж, тухайн орчинд хууль бус ашиглалт буурна.	ААНэгжийн хөрөнгөөр
2.4	АМТХууль, ЗГазрын 151-р тогтоол	Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нөхөрлөлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих	2,3-р улиралд	Зөрчил буурна.	2,000,000
2.5	Байгаль хамгаалах дэд хөтөлбөр 3.3.18, 3.3.19	Хог хаягдлын тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх, Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, зохион байгуулах.	Тухай бүрд	Хуулийн хэрэгжилт сайжирч, цэвэр орчин бүрдэнэ.	1000,000
Нийт дүн					13,000,000

3738639 СТА0122  
 БОХУБ, БХ  
 2023.07.18

....000....